

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255013>

“ЛҮН ФҮ СЭ-ИЙН ГЭСЭР”-ИЙН ТУУЖИЙН
СУРВАЛЖИЙН АСУУДАЛД

С.Дашдэжид 

Хураангуй: Энэхүү өгүүлэлд уран зохиолын бичвэр судлалын аргыг баримтлан монгол Гэсэрийн туужийн нэг хувилбар болох “Лүн Фү Сэ-гийн Гэсэр”-ийн туужийг хэрхэн монголжсон болохыг өгүүлэмж, монгол шүлгийн тогтолцоо болон бусад сурвалж бичгүүдтэй ямар харилцан холбоотой болохыг тодруулахыг зорилоо. Гэсэрийн тууж нь сонгодог монгол бичгийн хэлээр уламжилсан түүхэн сурвалжуудтай нэгэн цаг үед зэрэгцэн зохиогдсон нь тодорхой юм. Энэ цаг үеийн сурвалж бичиг зохиогчид ямар нэгэн байдлаар урьдах зохиолыг ашигласнаа дурдсан байдаг. Эдгээр сурвалжуудыг тодорхой цаг үеийн өөр өөр хүмүүс зохиосон боловч зохиомж, өгүүлэмж нь өмнөх үеэс уламжлан өртөөлсөн залгамж холбоо, харилцан нөлөөллийн асуудлыг бичвэр судлалын үүднээс судлах шаардлага гардаг. Эхийг дахин хувиргахдаа зохиомж, дүр, өгүүлэмж, хэл найруулга, агуулга хэлбэрийг давтах, өөрчлөн баяжуулах аргыг ашиглан шүлгүүдийн бүтэц, айзам хэмнэл, утга агуулга нь дараа дараагийн эх бичвэрүүдэд адил төстэй байх нь нийтлэг зүй тогтолтой болохыг судалгааны үр дүнгээр батлах юм.

Түлхүүр үг: Бичвэр, хувилбар, түүхэн сурвалж, Гэсэрийн тууж, өгүүлэмж, шүлгийн тогтолцоо

Keywords: Text, version, historical source, the Epic of Geser, motif, poetic system

Удиртгал

Гэсэрийн тууж нь Төв Азийн ард түмний дунд аман болон бичгээр дэлгэрэхдээ Төвөд Гэсэр, Монгол Гэсэр, Буриад Гэсэр, Халимаг Гэсэр, Тува Гэсэр гэсэн хувилбараар тархжээ.

Монгол Гэсэрийн туужийн “Бээжин барын Гэсэр”, “Лүн Фү Сэ-гийн Гэсэр”, “Лин Гэсэр буюу Замлин Сэнчиний намтар”, “Номч хатны Гэсэр”, “Заяын Гэсэр”, “Ойрд Гэсэр”, “Устын зуугийн Гэсэр”, “Харчин Гэсэр”, “Цэвээний Гэсэр” гэсэн хувилбарууд агуулгын хувьд адилавар боловч хэмжээний хувьд товч, дэлгэрэнгүй адил бус байдаг. Эдгээр хувилбаруудын бичигт тэмдэглэсэн он цаг, бичээчийн тухай болон бусад мэдээлэл тодорхойгүй байна. Бид Гэсэрийн туужийг эртнээс мэддэг байсан бөгөөд үлгэрч, туульчдын амнаас ам дамжихдаа тухайн нутаг орны байдал, угсаатны хэл, соёл, сэтгэлгээний онцлогийг шингээн өөрчлөгдсөн төдийгүй шинэ өгүүлэмж нэмэх, хасах зэргээр чөлөөтэй найруулан хэлдэг байжээ. Мөн хожмын бичээчид гар дамжуулан хуулахдаа өөрийн үзэл баримтлал, бодол санаа, мэдээ мэдээллийг нэмж оруулах зэрэг байдлаас үүдсэн хувилбарууд бий болжээ. Тухайлбал,

Гэсэрийн туужийг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсан эрдэмтэн Ц.Дамдинсүрэн “*“Бээжин барын Гэсэр” нь 1716 онд Бээжин хотод модон бараар*

барлагдсан долоон бүлэг болно. Ленинградын номын санд байгаа гучаад бичмэл Гэсэрийн туужийг шалгаж үзвэл тухайн үед байсан цор ганц бичмэл эхийг авч хэвлэсэн бус, олон эхүүдээс сонгон хэвлэсэн байна.

“Номч хатны Гэсэр” нь “Бээжин барын Гэсэр”-ийн нэг хувилбар болно. Тэгэхдээ бусад эхээс алдаа мадаг цөөнтэй арай сайн эх юм. Энэ хувилбарын төгсгөлийн үгэнд “Лам эрдэнэ, Гэсэр хаан хоёр золголцсон судар оршвой” хэмээх нэртэй жижиг сургаалыг Номч хатны дуртгасан ёсоор Богвон эрдэнэ Эрх цорж төвөдөөс монгол хэлэнд орчуулсан байна. Энэ тухай төгсгөлийн үгэнд бичжээ. Гэтэл энэ жижиг сургаалыг дуртган орчуулуулсан Номч хатныг бүхэл Гэсэрийн туужийг орчуулсан буюу үүдсэн хүн мэтээр үзэж “Номч хатны Гэсэр” гэж нэрлэсэн нь илэрхий алдаа болно.

“Заяын Гэсэр” хуучны Заяын хүрээ, одоогийн Цэцэрлэг хотоос 1930-аад оны үед олдсон. Энэ Гэсэрийн туужийн дотор “Бээжин барын Гэсэр”-ийн 7 бүлэг цөмөөр багтан оржээ. Тэгэхдээ “Бээжин барын Гэсэр”, “Заяын Гэсэр” хоёрын ерөнхий утга нийлэх боловч үг үсэг харилцан тохирохгүй. Энэ туужийг хоёр өөр хүнд дам хэлж бичүүлээд хоёрдугаар тууж бүтсэн байж мэднэ.

“Лин Гэсэр” хожим “Замлин Сэнчиний намтар” нэртэйгээр 1959 онд хэвлэгдсэн. Монгол “Лин Гэсэр” их сонирхолтой тууж юм. Өөр туужид байхгүй олон тодорхой мэдээ “Лин Гэсэр”-т байна” (Дамдинсүрэн 1977:9-11)

гэхчилэн Гэсэрийн туужийн олон хувилбарыг харьцуулан судлаад эхүүдийн зөрөөтэй байдлын тухай санал дэвшүүлсэн байна.

Монгол Гэсэрийн туужийн эх сурвалжийн тухайд “...орчуулгын зохиол бөгөөд түүнийг төвөд Гэсэрийн туужаас орчуулсан хэмээн нэлээд ул үндэстэй үзэл баримтлал байдаг. Монгол Гэсэрийн туужийг уншсан хэнд ч болов энэхүү нотолгоо үнэн гэдэгт эргэлзэх зүйлгүй бөгөөд түүгээр төвөд Гэсэрийн агуулгыг ч барагцаалж болно” (Дамдинсүрэн 2013:38) гэж үзсэн. Юутай ч Гэсэрийн туужийн бусад хувилбаруудад төвөд Гэсэрийн “Арван зүгийн арван хорын үндсийг тасалсан ачит богд Гэсэр мэргэн хаан алдаршсан” бүлэг, “Шарай голын гурван хааны төрийг авсан” бүлэг бараг тэр хэвээр байгаа тухай судлаачид тэмдэглэсэн байна. Мөн төвөд Гэсэрийн туужийн баатруудын нэр (Гэсэр Сэрво Дондүв, Арья Авалоки Одкари, Арья Аланкари, Жамцо Дари Оддам, Овоо Дүнжонгарво, Ронца, Сэнлон, Царгин, Зас Чихэр), газар усны нэр (Дос, Донсар, Жало, Лин) монгол Гэсэрийн туужид хэвээр хадгалагдан дэлгэрсэн байна. Харин монгол үлгэрч нарын нэмж дэлгэрүүлсэн бусад бүлгүүдэд төвөд нэрийг монголчилон (Рогмо хатныг Алтан дагина, Арлан гуа хатныг Түмэнжаргалан, Гэсэрийн эмэг эх Гүнман жалмог Навса Хүрээ эмэг эх гэх мэт), монгол ахуй, соёл, монгол баатрын дүр төрх түлхүү дүрслэгдсэн төдийгүй монгол шүлгийн тогтолцоо, онцлог зэргийг шингээж баатарлаг туулийн хэв шинжтэй болсон байна.

Аливаа ард түмний уран зохиолын хэлхээ холбоо, харилцан нөлөөлөл нь юуны өмнө орчуулгаар дамждаг мөн зохиол бүтээлийн агуулга, үзэл санаан дээр суурилж тухайн ард түмний ахуй амьдрал, хүсэл тэмүүлээр баяжигдан дэлгэрдэг. Ингэхдээ зарим зохиол бүтээл нь ард түмний дунд амаар түгэж монгол дүр төрхийг олсон, зарим нь хэсэг бусгаар монгол зохиолд оруулбар байдлаар шингэсэн гэх зэргээр нөлөөлсөн зүйл ажиглагддаг. Монголчуудын харь хэлнээс хийсэн орчуулгын уламжлалыг сонирхон үзвэл,

VIII-XIV зууны үед монголчууд уйгур, перс, араб, хятад, төвд, санскрит хэлнээс төрөл бүрийн эрдэм ухааны зохиолыг монгол хэлнээ орчуулж байсан

бөгөөд үүний дотор Энэтхэгийн “Панчатантр”-ын алдарт үлгэрүүдийн араб перс хувилбар “Калилэ-вэ-Демене” нэрт зохиолыг перс араб хэлнээс, Монголын хоёр хэлийг өгүүлэгч Чойжи-Одсэр бандида Энэтхэгийн гүн ухааны яруу найраг “Бодичарияавадараг” санскрит хэлнээс, мөн нэрт орчуулагч Сономгара төвөдийн иргэний яруу найргийн алдарт цоморлиг “Субашид”-ыг төвөд хэлнээс, тэр үеийн монголын судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн, орчуулагч Бортөмөр, Алинтөмөр нар “Ачлалт ном” зэрэг төр иргэний олон шастир сургаалыг хятад хэлнээс, Бүддийн утга зохиолын гурван аймаг сав номын төгс төгөлдөр мэдлэгийг эзэмшсэн Уйгурын эрдэмтэн Цилонадаши, Брадирашири, Карунадас нар санскрит, төвөд судар шастырыг уйгур хэлнээс орчуулж байв (Хүрэлбаатар 2002:113).

Мөн 1264 онд хятадын сонгодог зохиол орчуулах, түүх зохиох хороог байгуулсан нь харь хэлнээс судар ном орчуулах ажлыг улам эрчимжүүлсэн байдаг. Тухайлбал, Энэтхэгийн “Панчатантр”-ын үлгэрийн цомирлогоос “Охин болсон хулганы үлгэр”, “Ухаант туулай, омогт арсланг дийлсэн үлгэр”, “Их дагзат мэлхийн үлгэр” зэрэг үлгэрүүд агуулга, зохиомжийн хувьд монгол үлгэрийн хэв шинжтэй болсон. Сажа бандида Гунгаажалцаны зохиосон “Субашид”-ын шүлэг сургаалыг монгол ахуй, сэтгэлгээнд нийцүүлэх тал дээр ихээхэн анхаарч байснаа сүүлдээ шууд иш татан авахсан жишээ “Оюун түлхүүр” зэрэг сургаалын зохиолд тодорхой харагддаг. Ийнхүү орчуулгын зохиол монголын уран зохиолд нөлөө хүртээсэн тодорхой жишээ олон бий. Дэлхий дахины сонгодог өв, эрдэм мэдлэгийг орчуулан судлаж, өөрсдийн утга зохиолын баялаг санг арвижуулсаар ирсэн байна. Эдгээр орчуулгын бүтээлүүдийн нэг төвөд Гэсэрийн тууж болох нь дамжиггүй боловч хэн хэзээ, хэрхэн орчуулсан тухай магадтай мэдээ одоо хир нь алга байна. Ямартай ч хэдийгээр монгол Гэсэр туужийн эх сурвалж орчуулгын зохиол боловч бид өөрсдийн түүх, аж байдал, хүсэл эрмэлзэл, хүслэнгийн баатруудаар баяжуулан монгол зохиол болгосон нь илэрхий байна.

“Гэсэрийн туужийн жишээгээр үзэх юм бол төвөд туульсын өгүүлэгдэхүүн-сэдвийн цөмийг дахин боловсруулж, нийт монгол угсаатны их туульсын анхдагч эх түлхэц болгосон нь мэдэгдэх бөгөөд ном бичгийн туульсын хэлбэрийн эхийг хатгасан, монгол хэлтний уран зохиол-аман зохиолын хэлхээ холбоог эрчимжүүлсэн нь ойлгогдоно. Энэ бол цорын ганц яруу жишээ биш бөгөөд гаднаас ардын туульс орж ирсэн аман зохиол-домог зүйн болон уран зохиолын тоо хэмжээ түүхэн хөгжлийн тодорхой шатанд арвин байгаа нь ерийн байдаг зүйл болохоос биш, хэм хэмжээнээс гажсан юм огт биш. Энэхүү дүгнэлт монгол угсаатны туульсын туурвилын үндэсний өвөрмөц байдлыг огтхон ч доортгохгүй хэмээн бодно” (Неклюдов 1984:264-267)

гэж үзсэн байна. Уран зохиолын харилцаа холбоо, уламжлал шинэчлэл хөгжлийн зүй тогтол, туурвил зүйн хувьд аман зохиолоос бичгийн уран зохиол бүрэлдэн тогтож, эргээд бичгийн уран зохиолоос аман зохиолд нөлөөлөх, орчуулын уран зохиол тухайн ард түмний зохиолд нутагших, оруулбар хэлбэрээр зохиомжлогдох гэх зэргээр тухайн ард түмний уран зохиолыг баяжуулан дэлгэрүүлж байдаг.

Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлэлдээ, монгол Гэсэрийн туужийн эх сурвалж орчуулгын зохиол гэж үзвэл, “Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн туужийг хэрхэн монгол зохиол болгосон тухай асуултад хариулт өгөхийг зорилоо. Ингэхдээ бичвэрийг харьцуулах, тодруулах аргын хүрээнд авч үзэх болно.

Бичвэр (аливаа зохиол, бичгээр илэрхийлэгдсэн зүйл) хоорондын хамаарал буюу бичвэр сүлэлдээний арга (*intertextuality*) гэж нэг бичвэр нөгөөтэйгөө ямар нэг байдлаар холбогдож буйг хэлнэ. Бичвэр хоорондын хамаарал нь юун түүвэнд шууд эсвэл шууд бус эшлэл хэлбэртэй байж болно. Тухайн эш татаж буй зохиолын нэрийг ил тод дурдах байдлаар эшилж буй бол шууд эшлэл, дурдахгүйгээр далдуур эшилж буй бол шууд бус эшлэл гэнэ (Галбаатар 2012:80-83). Энэхүү бичвэр сүлэлдээний аргаар туульсыг баялаг өгүүлэмжтэй, сонирхолтой болгодог.

Бүтцийн онолд туульч адил бус туулийг хайлахдаа нэг зүйлийн үндсэн бүтэц бүрэлдэхүүн-мотив элемент буюу үндсэн үйл явдлыг дахин дахин хэрэглэж, маш олон туулийн зохиолуудыг зохион бүтээдэг гэж үздэг. Туульчаас тууль хайлах болгонд зохиомол дүрийг хувиргах буюу зохиомол дүрийн ажиллагааны хувиралтын дэс дарааг дахин цогцлоох аргаар адил бус туулийн зохиолуудыг зохион тоглож, үй олон аман туулийн ертөнцийг бий болгожээ гэж тайлбарладаг (Propp 2009:xi). Уран зохиолын хэлбэр, бүтэц зохиомжийг судлахдаа тодорхой загварт оруулж схемчлэх маягаар судалдаг. Туульсын зохиолын харилцан нөлөөллийг бүтэцлэн үзсэнээр зохиомжийн хэв шинжийг тодруулахад үр дүнтэй юм.

Судалгааны эх хэрэглэгдэхүүн

“Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн туужийн тухайд,

- “Лүн Фү Сэ-ийн Гэсэр” нь “Бээжин барын Гэсэр”-ийн долоон бүлгийн үргэлжлэл шинжтэй зургаан бүлэгтэй, агуулгын хувьд нэн баялаг, монгол шүлгийн уламжлал, айзам хэмнэл, уран яруу хэрэглүүрийн хувьд сонирхолтой нэгэн хувилбар юм.

- Зургаан бүлэг Гэсэрийн туужийг 1954 онд Бээжингийн Лүн Фү Сэ хийдийн дэргэдэх хуучин номын дэлгүүрээс судлаач Мэргэнбаатар олсныг 1989, 2002, 2016 онуудад хулсан үзгийн эхээр тус тус хэвлэжээ. Судлаачид уг эх нь хадгалагдаж байсан газраар нь “Лүн Фү Сэ-ийн Гэсэр” гэж нэрлэсэн бөгөөд одоо Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнд хадгалагдаж байна.

- 1956 онд Өвөр монголын ардын хэвлэлийн хороо “Бээжин барын Гэсэр”-ийн доод дэвтэр болгон хэвлүүлсэн. Энэ судар “Гэсэрийн наймдугаар бүлэг оршив” гэсэн гарчигаар эхэлдэг. Нийт 276 хуудас, 551 талтай, хулсан үзгээр бичсэн уг судрын хуудасны хэмжээ 50.24 см×18.34 см бөгөөд тал бүрд нь 25-26 мөр үсэгтэй. Энэ хувилбарын хэл найруулга нь сонгодог монгол бичгийн хэлнээс ихээхэн ялгаатай бөгөөд Хөхнуурын ойрдуудын ярианы хэлэнд ойр.

“Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн тухай судлаачдын санал таамгийг авч үзье.

“Лүн Фү Сэ-гийн Гэсэр”-ийн туужийг “Бээжин барын Гэсэрийн туужийн үргэлжлэл гэж үздэг” (Гэрэлт 2016:109), “Лүн Фү Ши-гийн бичмэл дэвтэр бол Бээжингийн “модон барын Гэсэр”-ийг үргэлжлүүлэн зохиосон бөгөөд арай боловсруулж амжаагүй шинжтэй” (Чойралжав 1986:183), ““Лүн Фү Сэ-ийн

Гэсэр”-ийн VIII, IX бүлгийг шинээр зохиосон, X, XI, XII, XIII бүлгүүдийг “Бээжин барын Гэсэр”-ийн зарим бүлгийн өгүүлэмж, үйл явдал, зохиомжийг ашиглан баяжуулан зохиохдоо номт гурван улсын аман ба бичгийн уран зохиолын хэв маягийг шингээжээ. Мөн Монголд бурхны шашин ихэд дэлгэрч байсан цаг үе, нийгмийн нөлөө тусгал тод харагдаж байна” (Дашдэжид 2023:318)

гэсэн санал дэвшүүлсэн байна. Ийнхүү үргэлжлүүлэн зохиохдоо ямар эх сурвалж ашигласан болохыг тодруулах нь зүйтэй юм.

Юун түрүүнд, сонгодог монгол бичгийн хэлээр уламжилсан түүхэн сурвалжуудтай нэгэн цаг үед зэрэгцэн зохиогдсон нь тодорхой юм. Энэ цаг үеийн сурвалж бичиг зохиогчид ямар нэгэн байдлаар урьдах зохиолыг ашигласнаа дурдсан байдаг. Үүнд, Лувсанданзан “Алтан товч”-оо зохиохдоо “Монголын нууц товчоо”-г, Жамбадорж “Болор толь”-ийг зохиохдоо Мэргэн гэгээний “Алтан товч”-ийг, Мэргэн гэгээний “Алтан товч”, Рашпунцаг “Болор эрхи”-ийг зохиохдоо “Алтан хүрдэн мянган хигээст бичиг”-ийг, Жамба “Асрагч нэртийн түүх”-ийг зохиохдоо “Хөх дэвтэр”, “Залуусын хурим”-ыг, Саган сэцэн “Эрдэнийн товч”-ийг зохиохдоо “Цагаан түүх”, “Шар тууж”-ийг ашигласан тухай олон баримт дурдаж болно. Эдгээр сурвалжуудыг тодорхой цаг үеийн өөр өөр хүмүүс зохиосон боловч зохиомж, өгүүлэмж нь өмнөх үеэс уламжлан өртөөлсөн залгамж холбоо, харилцан нөлөөллийн асуудлыг бичвэр судлалын үүднээс судлах шаардлагатай байдаг. Эхийг дахин хувиргахдаа зохиомж, дүр, өгүүлэмж, хэл найруулга, агуулга, хэлбэрийг давтсан, өөрчлөн баяжуулах аргыг ашигладаг. Тиймээс сурвалжуудад тэмдэглэгдсэн шүлгүүдийн бүтэц, айзам хэмнэл, утга агуулга нь дараа дараагийн эх бичвэрүүдэд адил төстэй байх нь нийтлэг ажиглагддаг.

Үндсэн хэсэг

“Гэсэрийн тууж”-ийн эх бичвэрийн судалгаанд дараах асуудлыг онцгойлон анхаарав.

“Бээжин барын Гэсэр”-ийн үргэлжлэл болох “Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн туужийг зохиохдоо ямар эх сурвалжийг хэрхэн ашигласан бэ?

“Бээжин барын Гэсэр”-ийг үргэлжлүүлэн зохиохдоо, тухайн цаг үед олны дунд тархсан аман болон бичгийн сурвалжийг ямар нэгэн байдлаар ашигласан нь тодорхой юм. “Хаадын үндэс хураангуй Алтан товч” (1604), “Чакраварди Алтан хааны төрлийг ухуулах Эрдэнэ толь нэрт хураангуй цадиг” (1618), Лувсанданзан гүүшийн “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх судар оршив” (1634), “Эртний Монголын хаадын үндэс Их шар тууж оршив” (1650), Саган сэцэний “Хаадын үндэс Эрдэний товч” (1662), Жамбын “Асрагч нэртийн түүх” (1676) зэрэг түүхэн сурвалжууд зохиогдсон цаг үетэй хамаатуулан үзэх нь зүйтэй болов уу.

Ийнхүү үзэх учир юун гэвэл, “Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн туужид өмнөх үеийн аман сурвалжаар дэлгэрсэн үлгэр, туульс, домгийн өгүүлэмж, баатруудын дүр төрх болон түүхэн сурвалж бичгээр уламжлагдсан домог, сургаалын шүлгүүдийн нөлөө тусгал ажиглагддаг. Тухайлбал, “Гурван зуун тайчуудыг дарсан домог”¹-т эзэн Чингис хаан зургаан сайдаа магтан сайшаасан шүлгийн агуулга, зохиомж, тогтолцоо нь Гэсэр богд Шарайголын тулаанд эндсэн гучин баатар, гурван зуун

¹ Энэхүү домог “Чингис хааны алтан товч нэртийн цэди”, Лувсанданзаны “Алтан товч”, Инжаннашийн “Хөх судар”-аар дамжин уламжлагдан ирсэн. Домгийн тухай Ж.Цэвээн, Ц.Дамдинсүрэн, В.Хайссиг, Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном, Г.Нарантунгалаг нарын эрдэмтдийн судалгааны өгүүлэл бий.

хошуучийнхаа алтан ясан дээр баатруудынхаа алдар гавьяаг магтан харуусан гашуудаж хэлсэн шүлэгтэй агуулга, бүтэцтэй адил байна. Тиймээс “Гурван зуун тайчуудыг дарсан домог”-ийг “Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн “Шарайголын дайнд эндсэн баатруудыг амилуулсан” наймдугаар бүлэгтэй харьцуулан үзэж сурвалж хоорондын уламжлал, шинэчлэлийн асуудлыг анхаарч үзлээ.

1. Бүтэц онолын үзэл баримтлалаар өгүүлэмжийг харьцуулах нь

“Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн туужийн өгүүлэмжийн хэв шинж нь дараа дараагийн хувилбарт дахин давтах аргаар бүтцийг бий болгожээ. Леви-Стросс “домгийн бүрдэл нэгжүүд нь тус тусдаа харилцаанууд биш, харин энэхүү харилцаануудын багц байдаг. Эдгээр багцын зохицлоор домгийн бүрдэл нэгжүүд нь үйл ажиллагааны утгатай болдог” (Levi Strauss 1955:432) гэж тайлбарласан. Ийнхүү домгийн бүтцийг зөв бүлэглэж чадвал зохиомж, өгүүлэмжийг шинээр эмхэлдэг туршлагыг туулийн бүтцийг судлахад мөн ашиглаж болох юм. Парадигматик анализ нь Леви-Строссын бүтцийн антропологид тулгуурлах бөгөөд тухайн текстийн дотоод гүн давхаргад буй хосмолжин эсрэгцэл (*binary opposition*)-ийг оюун санаа болон бусад зүйлсийг түгээмэл шинж чанартай холбон тайлбарлаж, өгүүлэмж хөөж, үг тоолдог судалгааныарга (Соёлмаа 2019:78) бөгөөд нийтлэг үйл явдлуудыг ижил ижлээр нь тусдаа баганад багцлан, доор үзүүлсэнтэй төстэй матриц бий болдог.

Ийнхүү парадигматик анализаар үйл явдлын харилцаанд багцалснаар харьцуулж үзье.

	Парадигматик анализын матриц	Гурван зуун тайчуудыг дарсан домог Эзэн толбот бор	Лүн Фү Сэ-ийн Гэсэр
Эхний багана:	хортон авахыг хүсэмжлэх, саадыг давж эргэн уулзах, бусдын хүслийн эрхшээлд автах	мориныхоо дэл дээр нь ташуураа тулж үүрэглэхүйдээ зүүдлэв. Зургаан сайддаа зүүдээ хэлэв.	Шарай голын гурван хаантай тулалдсан тулалдав.
Хоёр дахь багана:	хариу үйлдэл үзүүлж буйг илтгэх эсэргүүцэл, тулаанд бэлтгэх	Гурван зуун тайчууд ирж байна гэв. Тайчуудыг угтан цавчилдая гэв. Тулаанд бэлдэв.	Тулаанд члагдан гучин баатар, гурван зуун хошууч нь амь эрсдэв.
Гурав дахь багана:	өрсөлдөгчөө ялахын тулд шидэт туслагч эсвэлхатнаасаа тусламж авах	Зургаан сайдууд нь тулаанд оров.	Гэсэр хаан амь эрсэдсэн гучин баатар, гурван зуун хошуучийнхаа алтан ясан дээр ирээд гашуудан хайлав. Ялгуусан гурван өхий нь туслав.

	шидэт туслалчийнхаа		Баатрууд нь Хурмаст тэнгэр, Шагжамуни, ялгуусан гурван өхийн туслалцаатай сэхээ оров.
Дөрөв дэх багана:	ачаар өрсөлдөгчдөө хохирол учруулах, хортоны хүч чадлыг нь бууруулах	Зургаан сайдынхаа хүчээр тайчуудыг ялав.	
		Чингис хаан тулалдан ялсаны дараа зургаан сайдаа сайшаан магтав.	Баатрууд нь Эзэн богдоо магтав.
Сүүлийн багана:	зорилгоо биелүүлэх, дайснаа дарах	Боорчи Эзэн богдыг магтав. Чингис хаан гэртээ хүрч ирээд, энх амгалан суув.	Арван зүгийн эзэн богд Гэсэр хаан аливаа бүгд юүгээ төгсгөж, амгалангаар жарган суув.

гэсэн харилцаагаар үйл явдал өрнөж байна.

“Гурван зуун тайчуудыг дарсан домог”, “Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн VIII бүлгийн парадигматик бүтцийн тухайд матрицыг харьцуулан үзвэл тулаанд бэлтгэх, өрсөлдөгчөө ялахын тулд шидэт туслалчаас туслалж авах, шидэт туслалчийнхаа ачаар өрсөлдөгчдөө хохирол учруулах, хүч чадлыг нь бууруулах, зорилгоо биелүүлэх, дайснаа дарах гэсэн харилцаа ижил байна. “Гурван зуун тайчуудыг дарсан домог”-т баатрын ар гэр, хатад, газар нутгийг булаахаар санаархсан Тайчуудыг дарж байгаа нь монгол туульсын нийтлэг өгүүлэмжийн хэв шинжит харин “Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн VIII бүлэг нь гол баатрын эд хөрөнгө, эдлэл хэрэгсэл, нутаг орныг булаахыг хүссэн Шарай голын гурван хааныхан Гэсэрийг эзгүй хойгуур гучин баатар, гурван зуун хошуучийг нь эндүүлснээр эхэлж байна. Гэсэр хаан орон нутагтаа эргэн ирээд хортон дайсанд алагдсан баатруудаа сэхээ оруулах зорилгыг гол өгүүлэмжээ болгосон. Мөн Хурмаст тэнгэр, Шагжамуни, ялгуусан гурван өхийн туслалжтайгаар баатруудаа сэхээ оруулж байгаа өгүүлэмжээр баяжигдсан өвөрмөц сонирхолтой бүлэг юм.

Энэ матрицаар хоёр зохиолын ерөнхий өгүүлэмж ижил байгаа боловч нэг зохиолд нь ялалтын дараа баатруудаараа бахархан угсаа гарал, эрдэм чадал, гавьяа үйлсийг нь магтан сайшаасан бол нөгөө зохиолд нь харуусан гашуудаж угсаа гарал, эрдэм чадал, гавьяа үйлсийг нь дурсан санагалзаж буйгаар зохиомжилсон байна. Энэ нь үхэл-амьдрал, ялалт-ялагдал гэсэн эсрэгцэл, зөрчилт харилцааг бий болгож, амьдралын гол шалгуур нь тэмцэл бөгөөд саадыг давж, бэрхшээлийг туулснаар сайн сайхан, амар амгаланг бий болгодог гэсэн санааг илэрхийлсэн байна.

1. Шүлгийн бүтцийг задлан шинжлэх нь

Гэсэр хаан Шарай голын тулаанд эндсэн гучин баатар, гурван зуун хошуучийнхаа үхэлд харамсан гашуудаж хэлсэн гашуудлын шүлгийн бүтцийг задлан шинжилж “Гурван зуун тайчуудыг дарсан домог” болон “Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн туужийн баатруудыг магтсан шүлгийн харилцан хамааралтай эсэхийг тодруулахыг зорилоо.

Ингэхдээ монгол шүлгийн хос мөрөөс бүтсэн, үг үеийн тоо, толгой сүүл нь хосолсон, эн зэрэгцэх үгийн хэл зүйн хэлбэршил, зүйрлэл адилтгал, утга лавшруулсан давталт зэрэг онцлогийг хэрхэн хадгалсан болохыг ажиглана.

Шүлэг холбох арга

Хоёр буюу хэд хэдэн шадьг ижил буюу төсөөт авиаг ижилсүүлэн эрэмбэ дараалалд оруулж холбох янз бүрийн аргуудыг бүхэлд нь холбоц гэнэ. Холбоц нь тухайн шүлгийг эгшиглэнтэй сонсогдоход, шүлгийн зохиомж, байгуулалтыг тодруулахад гол үүрэг гүйцэтгэдэг ч гэлээ, зөвхөн авианы чимэг дуудлага төдий биш утгын, хэмнэлийн агуулгыг өөртөө шингээсэн байдаг.

Лүн Фү Сэ-ийн Гэсэр

Хамгийн нагац болсон
Хар үгүй сэтгэлт
Халтирал үгүй чин зоригт
Хас эрдэнэ мэт зүрхт
Хар багаас хүчээ өгсөн
Хамгийн дарлага болсон
Буйдан минь аль эвүү яалаа?

Хар багаас хүчээ өгсөн
Хамгийн урьд харуул болсон
Харанхуй шөнө зул болсон
Хайран Буйдан минь эвүү яалаа? (2023:329)

Гурван зуун тайчуудыг дарсан домог

Найман шарга морийг нэхэхүйд
Нарыг гялтасхийж гарахуй цагт учирч
Насан бүр хүчээ өгсөн
Наху баяны хөвгүүн
Сайн хүлүг Боорчи минь!

....
Ханилахуй цагт
Хашин хар бяруу мэт аашт
Харьтан дайсанд
Харцгай шувуу мэт туулин довтлон орогч
Хүлүг Боорчи минь!

....
Хатуу дайсанд
Харил буцалгүй явж
Хаан эзнийхээ биеэс
Харин хол үл эчигч
Арга сайт хүлүг Боорчи минь!
(1990:49.b-50.a)

“Лүн Фү Сэ-ийн Гэсэр”-ийн туужийн Буйдан баатрыг магтан шүлэглэсэн шүлэг болон “Гурван зуун тайчуудыг дарсан домог”-т Боорчийн алдрыг магтсан шүлэгт АААА гэсэн зэрэгцэх, бүрэн, тууш холбоцтой байна. Ийнхүү толгой, сүүл холбохдоо авианы чимэг дуудлагыг баримталсан төдий бус утгын агуулгыг мөн харгалзан үзсэн байна. Сүүл холбохдоо,

Буйдан: *Хар багаас хүчээ өгсөн* (2023:329)
Боорчи: *Насан бүр хүчээ өгсөн* (1990:49.b)
Буйдан: *Хамгийн урьд харуул болсон*
Харанхуй шөнө зул болсон
Хайран Буйдан минь эвүү яалаа? (2023:329)
Боорчи: *Хатуу дайсанд*
Харил буцалгүй явж
Хаан эзнийхээ биеэс
Харин хол үл эчигч
Хүлүг Боорчи минь! (1990: 50.a)

гэхчлэн “болсон”, “өгсөн”, “минь” гэсэн үгсээр баатруудын алдар гавьяа, зан чанарыг магтсан мөрүүдийг харьцуулан тодотгон ижилсүүлэн салаавчилж холбосон байна. Сүүл холбоц ижил юм уу нэг төрлийн нөхцөл дагавраар холбогдохоос гадна төсөөт болон ойролцоо дуудлагатай үг, ижил үг, нийлэмж үгийг давтаж хэмжээ тааруулах нь бий.

Эн зэрэгцүүлэл арга

Эн зэрэгцэн бүхий хоёр мөр, хоёр бадаг, хэд хэдэн бадгийн үг хэллэг нь адил төстэй утга хэлбэрээр, найруулгын тэгш хэмийг чанд баримтлан давтсан байдаг. Толгой сүүл холбохтой адил зөвхөн авиа, үг ижилсүүлэх төдийгүй бүх л мөр бадгаар нь адилтган холбож, бас өгүүлсэн утга санаагаа улам лавшруулан тодруулдаг онцлогтой.

Мөн

Начин шонхор мэт жигүүрт
Арван таван настай эрдэнэт Нанчун минь аль эвүү яалаа? (2023:329)

Бурантаг үгүй заан мэт хүчит
Эрийн эр эрхт Шуумар минь эвүү аль яалаа? (2023:329)

гэсэн шүлгийн шадын төгсгөлийг “мэт жигүүрт”, “мэт хүчит” гэсэн үгээр зэрэгцүүлэн сүүл холбосон нь шүлгийг сонсголонтой, жигд хэмнэлтэй хэлэхэд эвтэй байхаар журамлагджээ.

Хоёр эхийн шүлгийн мөрийг зэрэгцүүлэн харьцуулвал,

Лүн Фү Сэ-ийн Гэсэр: *Арслангийн хумс болсон*
Амьтны ач болсон (2023:329)

Лу.Алтан товч: *Ороо гөрөөсний отолго болсон*
Оронготон дайсны хошууч нь болсон (1990:48.b)

Лүн Фү Сэ-ийн Гэсэр: *Хүний харцгай болсон*
Хүрэл эрдэнэ мэт зүрхт
Хүний урьд ирэгч
Амраг Засчихэр минь аль эвүү яалаа? (2023:329)

Лу.Алтан товч: *Ханилахуй цагт*
Хаашин хар бяруу мэт аашигт
Харьтан дайсанд
Харигай шувуу мэт туулин довтлон орогч
Хүлэг Боорчи минь! (1990:49.b)

Эдгээр бадагт харьцуулахад зарим үг хэллэгийн зөрүү байхаас биш, утга санааны хувьд онцын зөрүү багатай байна. Гол утга нь дайн дайсны дунд тулалдахдаа ан гөрөөний олз омогт шунан шунгах идлэг шонхор, харцгай, начин шувуу мэт байдаг хэмээн дайн тулаанд туулин довтлохдоо эрэмгий зоригтой, эргэлт буцалтгүй үнэнчээр “Өеөрхсэн бүргэд мэт яв” хэмээсэн нь тэр цагийн монголчуудын гол эрхэлдэг аж ахуй болох ан агнуур, мал ахуйн соёлтой шууд холбон “цоллон” зүйрлэжээ. Монгол хүний сэтгэлгээнд нүүдлийн ахуй амьдрал, мал аж ахуй, ан агнуур, араатан, жигүүртний авир төрх, үйл хөдлөл, өвөрмөц онцлогийг хамгийн сайн мэддэг тул хүний зан чанар, үйл хэрэгтэй эн зэрэгцүүлэн дүрсэлсэн мөрүүд цөөнгүй байна.

Энэхүү шүлгийн төгсгөлд хүлэг баатрууд нь эзнээ магтсан мөрүүдийг харьцуулвал,

Уг гарал:

Лүн Фү Сэ-ийн Гэсэр: Арван зүгийн арван хорын үндсийг таслан *төрсөн*
(2023:336)

Лу.Алтан товч: Есүхэй баатар *эцэгт*
Өгэлэн хатан *эхт* (1990:49.b)

Суу алдар:

Лүн Фү Сэ-ийн Гэсэр: Аливаа бүгдийн зүрхийг атган төрсөн
Арван зүгийн эзэн богд минь (2023:336)

Лу.Алтан товч: Ер таван өнгө, дөрвөн харь улсыг
Эрхэндээ оруулсан
Суут Чингис хаан эзэн минь (1990:49.b)

Гавьяа үйлс:

Лүн Фү Сэ-ийн Гэсэр: Дөрвөн тивийн амьтныг тэгш эзлэгч аугаа хүчит
Алтан дэлхий дээрх хамаг амьтныг тойндоо оруулагч
(2023:336)

Лу.Алтан товч: Өшөөтөн дайсныг
Өлмийдөө гишгэсэн (1990:50.a)

Хоёр эхэд утга дүйж байгаа зарим үгийн доогуур зурах, налуу болгох, тодруулах зэргээр ялган тэмдэглэв. Эдгээр нь дотроо дараах хоёр зүйлийн ялгавартай байна. Үүнд:

а. утга болон хэлбэр нь өөр үгс,

б. утга ойролцоо боловч үгийн хэлбэр нь өөр үгс

гэж ангилж болохоор байна. Ийнхүү харьцуулан үзэхэд зохиогч өмнөх эх сурвалжийг ашиглахдаа ерөнхий санааг нь авч, үг өгүүлбэрийг чөлөөтэй нэмж, хасах зэргээр өөрчилсөн найруулсан байна. Энэ нь түүхэн сурвалжуудыг зохиохдоо өргөн ашиглаж байсан найруулгын арга болох нь дээрх жишээнээс тодорхой харагдаж байна.

Дүгнэлт

Бээжингийн “модон барын Гэсэр”-ийг үргэлжлүүлэн “Лүн Фү Сэ-гийн Гэсэр”-ийн туужийг зохиохдоо сонгодог монгол бичгийн хэлээр уламжилсан түүхэн сурвалжуудтай нэгэн цаг үед зэрэгцэн зохиогдсон нь тодорхой байна.

“Лүн Фү Сэ-гийн Гэсэр”-ийн туужийн эхлэл болох “Шарайголын дайнд эндсэн баатруудыг амилуулсан наймдугаар бүлэг”-т Гэсэр хааны гашуудан хэлсэн харууслын болон баатруудын магтаал шүлэг нь “Чингис хааны алтан товч нэрийн цэдиг”, “Лувсанданзаны Алтан товч” зэрэг түүхэн сурвалж бичгээр уламжлагдан ирсэн “Гурван зуун тайчуудыг дарсан домог”-т эзэн Чингис хаан зургаан сайдаа магтсан болон Боорчийн эзнээ магтан шүлэгтэй адил өгүүлэмжтэй төдийгүй баатруудын угсаа гарал, байгуулсан гавьяа, зүтгэл, алдар нэр, ааш аягийг дурдсан шүлэгтэй ижил бүтэц, агуулгатай байна.

Түүхэн үйл явдлыг уран сайхны хэлбэрт оруулах, уран сайхны домгийг нэмэн дэлгэрүүлэх, хураан товчоолох нь XVII-XVIII зууны түүхэн сурвалж бичгүүдийн бичлэгийн үндсэн арга, тухайн цаг үеийн бичээчдийн бичих ур чадвартай шууд холбоотой байна.

Ном зүй

Эх хэрэглэгдэхүүн

Гэрэлт, (эмх.) (2016). Монгол Гэсэрийн цуврал бичиг “*Арван зүгийн эзэн Гэсэр хааны тууж оривой*” *Лүн Фү Ши хийдийн Гэсэрийн тууж*, Өвөр монголын хэвлэлийн бүлэглэл, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.

Дамдинсүрэн, Ц. (эмх.) (1986) *Гэсэр*. Улаанбаатар. Улсын хэвлэлийн газар.

Чингис хааны Алтан товч нэртийн цэдиг (2006, 2015) Монголын түүхэн сурвалжийн цуврал, №3, хөрвүүлэг тайлбар хийсэн С.Дашдэжид, Улаанбаатар. Соёмбо принт.

Lubsangdanjin, *Erten-ü qad-un ündüsülegsen törü yosun-u jokiyal-i tobčilan quriyaγsan altan tobči ketekü orusibai.* (1990) Orusil bičigsen Ša.Bira, Ulus-un töb nom-un sang-dur qadaγalaydaju bui Lubsangdanjin-u γar bičimel eke-eče gerel jiruy beledkegsen So.Törübatu, Ulaγanbaγatur. Ulus-un keblel-ün γajar,

Saγan sečen, *Erdeni-yin tobci* (1984) Kökeqota. Öbür mongγol-un ard-un keblel-ün qoriy-a.

Sečenmönge, (2002). *Geser-ün būrin bičig, terüγün boti*, Begejing. Ündüsüiten-ü keblel-ün quriy-a.

Судалгааны бүтээл: Монгол хэлээрх

Батхишиг,С, Дашдэжид,С (2023) *Гэсэрийн туужийн хэл, уран зохиолын судалгаа*, Улаанбаатар. Соёмбо принт.

Галбаатар,Д (2012) *Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл*, Улаанбаатар.

Дамдинсүрэн,Ц (1998) *Гэсэрийн туужийн түүхэн үндэс*, Улаанбаатар. Улсын хэвлэлийн газар.

Дамдинсүрэн Ц (2013) “Гэсэр судлал”-ын түүхээс. Улаанбаатар. Соёмбо принт.

Монгол уран зохиолын өгүүлэмжийн судалгаа, (2016) ШУА Хэл зохиолын хүрээлэн, Улаанбаатар.

Нарантуяа,Р (1999) *Монгол туулийн аман ба бичмэл хувилбарын шүтэлцээ*, (Эрийн сайн Ханхарангуй туулийн жишээн дээр), Улаанбаатар.

Соёлмаа С (2019) *Домгийн бүтэц-тэмдэг зүйн үүднээс шинжлэхүй* (Монголаман зохиолын жишээн дээр) Улаанбаатар. Соёмбо принтинг.

Хүрэлбаатар,Л (2002) *Судар шастирын билиг*, Улаанбаатар

Čoyiraljab (2018) Mongγol geser-ün sudululγan, Kökeqota. Öbür Mongγol-un soγol-un keblel-ün

Гадаад хэлээрх

Vladimir Propp (2009) *Morphology of the Folktale*, trans. Laurence Scott. Austin: University of Texas Press.

Неклюдов С.Ю (1984) *Героический эпос монгольских народов (Устные и литературные традиции)*.

Глав. Редакция Вост. Лит-ры, Москва.

Abstract

This article aims to clarify how the novel “Lun Fu Se’s Geser”, a variant of the mongolian “Geser tuuj”, was mongolized, and its motif, mongolian verse system, imagery, and interrelationships with the source texts, using the theory and method of literary textual studies. First of all, it is clear that it was composed at the same time as the historical sources transmitted in the classical mongolian script. The authors of the source texts of this period mentioned that they used the previous texts in some way. Although these sources were composed by different people at a certain time, there is a need to study the issues of continuity and mutual influence that the composition and motif were transmitted from the previous period from the perspective of textual studies. The results of the study confirm that there is a common pattern in which the structure, rhythm, and meaning of the poems are similar in subsequent original texts, using the method of repeating and enriching the plot, characters, motif, language, content, and form when re-transforming the original.